

## “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ДҮРИЙН СУДАЛГАА (БНХАУ-ЫН ЖИШЭЭН ДЭЭР 1949-2019)

Б.Хишигсүх  
Сурнаа (Surna)

**Хураангуй:** “Монголын нууц товчоо” дэлхийн олон хэлнээ орчуулагдаж, олон үндэстний уншигч, судлаачдын оюуны мэлмийд хүрч хэдэн арван жарныг өртөөлөн эдүгээд хүрээд байна. Бид “Монголын нууц товчоо”-г зөвхөн дүрийн судалгааны хүрээнд хилийн чанад дахь монголч эрдэмтдийн бүтээлийг бүхэлд нь эрж сурвалжлах, цуглуулах, нийтлэхээр “Хилийн чанад дахь “Монголын нууц товчоо”-ны дүрийн судалгааны тоймыг эхлүүлж байна. Уран зохиолын амин сүнс “дүр” бөгөөд судалгаа нь дүр шинжлэлээс эхэлнэ.

Энэ удаад БНХАУ дахь “Монголын нууц товчоо”-ны дүрийн судалгааны тухай өгүүлэх болно. 1959 онд Загчидсэцэн Монголын нууц товчооноос Чингис хааныг харах”<sup>1</sup> гэдэг өгүүллийг нийтлүүлж БНХАУ-д “Монголын нууц товчоо”-ны уран зохиолын судалгааны анхны хөшгийг сөхөв. Үүнээс хойш БНХАУ дахь “Монголын нууц товчоо”-ны уран зохиолын судалгааны хүрээнд их судлагдаж, хэдэн зуугаар тоологдох өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, нийтлэлийн анхдагч нь “Монголын нууц товчоо”-ны дүрийн судалгаа байж, үүний тойронд бусад салбар ухааны эрдэм шинжилгээний бүтээлүүд гарсаар байна.


Өгүүлэлд БНХАУ-ын 1949-2019 он хүртэлх хугацаанд хятад, монгол хэлээр нийтэлсэн “Монголын нууц товчоо”-ны дүрийн судалгааны үр дүнг эмхэтгэн задлан шинжлэхийн сацуу гол үзэл баримтлалыг хураангуйлан судалгааны нийтлэг тал, судалгааны төвлөрөл, онцлог зэргийг тодруулав. Тус судалгаа нь БНХАУ дахь “Монголын нууц товчоо”-ны уран зохиолын судалгааг гүнзгийрүүлэн ойлгоход тус нэмэр болох ба “Монголын нууц товчоо”-ны судалгаанд зайлшгүй практик ач холбогдолтой болно.

**Түлхүүр үг:** *Монголын нууц товчоо, дүрийн судалгаа, БНХАУ, тойм*

### Удиртгал

БНХАУ дахь “Монголын нууц товчоо” /цаашид “МНТ” гэж товчилно/-ны дүрийн судалгаа 1959 оноос эхэлсэн юм. Гэвч “соёлын их хувьсгал” -ын хор нөлөөнөөс судалгаа нь хориод жил зогсонги байлаа. 1980-аад оноос судалгаа сэргээгдэж богино буюу гучин жилийн хугацаанд 50 гаруй эрдэм шинжилгээний бүтээл хэвлэн нийтлэгдсэн байна .

<sup>1</sup> Загчидсэцэн. “Монголын нууц товчоо”-ноос Чингис хааныг харах. Өвөрмонголын “Өдрийн сонин” 1959.9.28. Хөх хот.



“Монголын нууц товчоо”-ны судалгааны хөгжлийн график (зургаар)

Судалгааны бүтээлүүдийг ажиглахад Чингис хааны дүрийн шинжлэл хамгийн идэвхтэй судлагдаж судалгааны голлох байрыг эзэлж байна. Судалгааны бүтээлүүдэд Чингис хааныг магтан сайшаах, зан чанарын давуу болон сул талыг илэрхийлэх, бусад түүхийн сурвалж, бичгийн дурсгалтай харьцуулах зэрэг агуулгатайгаар хийгджээ. Тэгвэл Чингис хааны нэгэн насны “нөхөр мэт дайсан”, “дайсан мэт анд” явсан Гүр хан Жамухын дүрийн шинжлэл нь БНХАУ-ын эрдэм шинжилгээний хүрээнд нэлээд өрнүүн явагдаж байсан бөгөөд эрдэмтдийн хооронд маргаан үүсгэж байв. Энэ нь чухам Жамухын дүрийн мөн чанарын асуудалд санал нэг байж чадахгүй байгаагаас үүдэлтэй болно. “Монголын нууц товчоо” дахь “эмэгтэйчүүдийн дүр”-ийн судалгаа ч хараахан шинэ шатанд гарч хийгдсэн гэхэд чамлахаар байна. МНТ дахь түүхэн хүмүүсийн дүрийн судалгаанд эмэгтэй баатруудын дүр шинжлэл нь Өгэлүн эх, Бөртэ-Үжин, Алунгоо эх зэрэг чухал байр суурьтай эмэгтэйчүүдийн талаар бичигдэж тэдний зан чанарын онцлог, үзэл ухамсрыг тусгахыг эрэлхийлж эртний монгол эмэгтэйчүүдийн байр суурийг хайн гаргах зэргийг судалгааны гол агуулгаа болгож байгаа хэдий ч бусад бүсгүйчүүдийн дүр, тухайлбал, Чингис хааны төрийн дөрвөн хатад болох Бөртэ-Үжинээс бусад Есүй, Есүгэн, Хулан, бас Чингис хааны охид, бэрүүд, бусад язгууртан эмэгтэйчүүд, алтан ургийнхан, бусад олон бүсгүйчүүдийн дүрийн судлал хийгдээгүй “Монголын нууц товчоо” дахь дүрийн судалгааны хоосон орон зай хэвээр байна. Үүнээс гадна Ван хан, Таян хан, Бодончар, Мухули, Бэгтэр, Бэлгүтэй, Хасар зэрэг бусад дүр шинжлэлийн хамаарал бүхий бүтээл цөөн ч гэсэн олдож олонх нь илтгэл буюу багахан дурдагдаж эсвэл харьцуулалд ашиглах төдийд байгаа нь бас л судлагдахуун эзнээ хүлээн буйг бэлхнээ илэрхийлнэ.

### Нэг. “МНТ”-ны Чингис хаан болон Жамухын дүр шинжлэл

**Чингис хаан:** Чингис хаан болон Жамухын дүрийн судалгааг эхлүүлэх анхны оролдлого хийсэн бичгийн хүмүүн бол Загчидсэцэн юм. Түүний “Монголын нууц товчоо”-ноос Чингис хааныг харах<sup>2</sup> гэдэг хятад хэлээр нийтлүүлсэн өгүүлэл нь БНХАУ дахь “Монголын нууц товчоо”-ны уран зохиолын судалгааны анхны бэлэг тэмдэг болсноор үл барам монголын сонгодог уран зохиолын судлалд ч чухал хувь нэмэр үзүүлсэн билээ. Өгүүлэлд “Чингис хааныг агуу их хүн чанартай, эрс бат үзэл сурталтай, хүнээс давсан авьяас билигтэй” гэх мэтээр магтан, зөв талаар үнэлсэн байна.

Судлаач Ч.Хишигтогтох, Ван Мандуга, Н.Сайшаалт нар ч “МНТ”-ны Чингис хааны дүрийг онцгойлон үнэлсэн байна. Ч.Хишигтогтохын “Чингис хаан- Монголын нууц товчоо”-ны хүмүүсийн зан чанарын тухай товч өгүүлэх нь<sup>3</sup> гэх өгүүлэлд нууц товчоон дахь Чингис

<sup>2</sup> Загчидсэцэн. “Монголын нууц товчоо”-ноос Чингис хааныг харах”. Өвөрмонголын “Өдрийн сонин” 1959.9.28. Хөх хот.

<sup>3</sup> Ч.Хишигтогтох. “Чингис хаан- Монголын нууц товчоо”-ны хүмүүсийн зан чанарын тухай товч өгүүлэх нь”.

хааны ой ухаан, хүч чадал хосолсон шилдэг зан чанарыг магтан сайшаажээ. Ван Мандугагийн “Нууц товчооноос Чингис хааныг үнэлэх нь”<sup>4</sup> гэдэг өгүүлэлд Чингис хааныг холын хараатай, уужим сэтгэлтэй, гарамгай улс төрч, шинээр мандсан феодал ангийн төлөөлөгч бөгөөд онцгойрсон цэргийн эрдэмтэн гэх мэтээр үнэлэн магтсан байна. Н.Сайшаалтын “Монголын уран зохиолын түүх”<sup>5</sup> гэдэг номын “МНТ” тусгай хэсэгт Чингис хааны зан чанарын онцлогийг “хүнд бэрхийг тэсвэрлэж шаргуу хатуужилтайгаар тэмцдэг, түмэн иргэний хүч чадал, ой ухааныг төвлөрүүлэн хэрэглэж чаддаг, хүнийг танихдаа чадамгай байдаг, шагнал шийтгэл чанга нямбай байдаг” гэх зэргээр хураангуйлан дүгнэв. Үүнээс гадна “МНТ” болон бусад сурвалж бичигт суурилан зөв талаар Чингис хааны дүрийг үнэлж сайшаасан бүтээл ч олон бий. Жишээ нь: “Чингис хааныг туршин өгүүлэх нь”<sup>6</sup>, “Чингис хааны хүн хэрэглэх ухаан”<sup>7</sup>, “Эзэн богд Чингис хааны дүр төрх”<sup>8</sup>, “Чингис хаан бол агуу их бодолготон мөн”<sup>9</sup>, “Чингис хааны итгэл бишрэлийн үзэл санаа-Чингис хаан бол агуу их бодолготон мөн гэх тухай гурвантаа өгүүлэх нь”<sup>10</sup> гэх зэрэг өгүүлэл нь зөв талаас нь Чингис хааны дүрийг задлан шинжилсэн байна. Үүний дотроос Чингис хааны хүнийг таньж хэрэглэхдээ чадамгай байдаг ба шагнал шийтгэл чанга нямбай зан чанарын онцлогийг судлаач Ч.Хишигтогтох, Р.Дамба, Р.Ганболд, Н.Сайшаалт зэрэг судлаачид дурдаж өнгөрсөн бөгөөд Чингис хааны ухаан бодолтой, тэсвэр хатуужилтай зан чанар ба агуу их цэрэг дайны эрдэмтэн, гарамгай улс төрч гэх үзлээр санал нэг байжээ.

Бас өөр хэсэг эрдэмтэн “МНТ” -ны Чингис хааны зан чанарын онцлогийг эерэг сөрөг талаас нь үнэлсэн байна. То.Дэлгэрсан “Монголын нууц товчоо”-ны урлагийн онцлогийн тухай анхны шинжлэлт” гэдэг өгүүлэлдээ: “МНТ-нд хэдийгээр Чингис хааны эрдэм чадал хосолсон хатуу зоригтой, эрэлхэг баатарлаг, арга ухаан төгс, холын хараатай сэцэн мэргэн зан чанарыг дээд зэргээр өргөн магтсан боловч бурхан шүтээн зэргээр ямар ч тодотголгүйгээр дүрсэлсэн ба харин түүний сэжиглэх дуртай, харгис догшин зэрэг занг ч илэн далангүй илтгэв.”<sup>11</sup> гэх бодлоо илтгэв. “Монголын нууц товчоонд дахь олон давхаргат соёл” гэдэг номд “Монголын нууц товчоо” дахь Чингис хааны дүр нь нарийн төвөгтэй хирнээ сайн муу олон талын зан чанар холилдон нэгдэж, өрөөсгөлөөр аль нэг талыг нь тасдан авч хэт өргөх буюу хэт муушаахаас зайлсхийх хэрэгтэй<sup>12</sup> гэсэн үзлээ дурдсан. Судлаач Д.Мөнхзаяа “Монголын нууц товчооны хүмүүсийн дүр (хоёр)” гэдэг өгүүлэлдээ Чингис хааны зан чанарын шалтгааныг сүвэгчилж Чингис хааны өөртэй нь тэмцэлдэх этгээд байхыг хүлцэж чадахгүй зан чанарын онцлогийг дурдсан байна. Эдгээр бүтээл нь бүгд “МНТ” дахь Чингис хааны дүрд харгис догшин тал оршиж байгааг хүлээн зөвшөөрч түүний сэжиг ихтэй зан чанар<sup>13</sup>-ыг дурдсан байдаг.

Ү.Тана, Жөү Мэй Чиүн, Жан Шү Пин, Сэргэлэн, Ин Цүн зэрэг судлаачид “МНТ”-ны Чингис хааны дүрийг бусад сурвалж бичигтэй харьцуулан шинжилж судалгаандаа дэлгэрүүлэн оруулсан байна. Үүнээс МНТ-ны Чингис хааны харгис хэрцгий зан чанарын дутагдал болон ахуйч үзлийн тухай Жан Шү Пин, Жөү Мэй Чиүн, Ин Цүн, Сэргэлэн нар санал нэг байжээ. Жөү Мэй Чиү-ний “Чингис хааны дүрийн уламжлалт болон хүлээн авалтын тухай өгүүлэх нь – “Монголын нууц товчоо”, “Юаний түүх”, “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар”-ын жишээн дээр”<sup>14</sup> гэдэг хятад өгүүлэлд “МНТ”-д Чингис хааны зан чанарын давуу тогоо талыг

Хөх хот. 1981.

<sup>4</sup> Ван Мандуга. “Нууц товчооноос Чингис хааныг үнэлэх нь”. Хөх хот. 1990.

<sup>5</sup> Н.Сайшаалт. “Монголын уран зохиолын түүх”. Хөх хот. 2017.

<sup>6</sup> Зо Бин Күн. Ли Гүй Жи. Чингис хааныг туршин өгүүлэх нь. Хөх хот. 1980.

<sup>7</sup> Р.Дамба. Чингис хааны хүн хэрэглэх ухаан. Хөх хот. 1993.

<sup>8</sup> Р.Ганболд. “Эзэн богд Чингис хааны дүр төрх”. Хөх хот. 1993.

<sup>9</sup> Наран-Очир. “Чингис хаан бол агуу их бодолготон мөн”. Хөх хот. 2005.

<sup>10</sup> Наран-Очир. “Чингис хааны итгэл бишрэлийн үзэл санаа-Чингис хаан бол агуу их бодолготон мөн гэх тухай гурвантаа өгүүлэх нь”. Хөх хот 2007.

<sup>11</sup> Т.Дэлгэрсан. “Монголын нууц товчоо”-ны урлагийн онцлогийн тухай анхны шинжлэлт”. Хөх хот.1981

<sup>12</sup> Сайн. “Монголын нууц товчоо” дахь олон давхаргат соёл. Хөх хот. 1990.

<sup>13</sup> Д.Мөнхзаяа. “Монголын нууц товчоо” -ны хүмүүсийн дүр”. 1995.

<sup>14</sup> В.Инжаннаши. “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар”. 1957.

нуулгүй илтгэсэн гэж “Юаний түүх” дэх Чингис хаан нь сэтгэхүйгээр зохиогдсон, Күнзийн сургаалтны онцлог бүхий өршөөлт энэрэнгүй дүрээр шууд бүтээгдсэн байна.”<sup>15</sup> гэжээ. Жан Шү Пинээс “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Чингис хааны дүрийн харьцуулал судлал “гэдэг өгүүллийг нийтлүүлж Чингис хааны төрж мэндэлсэн үеийн тухай дүрслэл, баатар, догшин хэрцгий хийгээд өршөөлт журамтын тухай дүрслэл гэгээн мэргэнийг товойлгосон дүрслэл болон шашны нөлөөг хүртсэн дүрслэл зэргээс “МНТ”-ны Чингис хааны дүрт гүнзгий задлалт хийсэн бөгөөд “Хөх судар”-т харин Чингис хааныг бүх талаар сайн дүрээр гаргасан<sup>16</sup> гэж үзлээ илтгэв. Ин Цүн “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-т илэрсэн Чингис хааны дүрийг харьцуулах нь” гэх өгүүлэлдээ хоёр сурвалж бичгийн Чингис хааныг бага нас, залуу нас, идэр нас гэж гурван үе шатаар харьцуулж “Хөх судар” дахь Чингис хааны дүр нь хүмүүсийн сэтгэлд агуу их нөлөө үзүүлэхийг хичээжээ.”<sup>17</sup> гэсэн үзлийг дэвшүүлжээ. Судлаач Сэргэлэн 2015 онд магистрын зэрэг хамгаалах өгүүлэл болох “Монголын түүхэн хүүрнэл дэх Чингис хааны дүрийн тухай шинжлэл” гэдэгтээ гурван сурвалж бичгийг ашиглаж “МНТ”-ны Чингис хааны дүрийг тэнгэрлэг шинж болон ахуйч шинж гэх хоёр талд хамран тайлбарлаж, Лувсанданзаны “Алтан товч” ба “Хөх судар” романы Чингис хааны дүртэй харьцуулжээ. Ү.Тана “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-ын уран дүрийг харьцуулан шинжих нь” гэдэг өгүүлэлдээ хоёр сурвалж бичиг дэх Чингис хааны дүрийг зөв талаас нь үнэлсэн бөгөөд “МНТ” дахь Чингис хаан бол үндэстний баатрын дүр болох ба “Хөх судар”-т Чингис хааныг зохиогчоос хувийн сэтгэлгээ шингээн санаачилгатайгаар шуун бүтээсэн хүслэнт дүр.”<sup>18</sup> гэсэн байна.

**Жамух сэцэн:** Өвөрмонголын болон хятадын хэсэг эрдэмтэд “МНТ” дахь Жамухын дүрийг сөрөг талын дүр гэж үздэг. Ч.Хишигтогтохын “Чингис хаан хийгээд Жамух сэцэн-Монголын нууц товчооны хүмүүсийн тухай өгүүлэх нь”<sup>19</sup> болон То.Дэлгэрсан “Жамухын нэг шүлгийг шинжлэх нь” гэдэг өгүүлэлд Тэмүжин, Жамух хоёрын салж явсан шалтгааныг Бөртэ-Үжиний хэлсэн “Жамух андыг уйдамхай зантай гэдэг”<sup>20</sup> гэснээс эш татан Жамух аливаа хүнтэй удаан нөхөрлөж дотно явах хүн биш, тогтворгүй зантай хүн мөн гэх үзлийг дурджээ. Үү.Тана “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-ын уран дүрийг харьцуулан шинжих нь”<sup>21</sup> гэдэг өгүүлэл болон Н.Сайшаалтын “Монгол уран зохиолын түүх” гэдэг номонд Жамухыг хоёр нүүртний дүр юм гэж хов жив зохиож бусдын хооронд хатган завсардуулах зан чанартай санал нэгдсэн байв.

Мөн зарим эрдэмтэд Жамухыг зөв талын дүр гэж үзсэн байжээ. Буян-Өлзий 1987 онд “Монголын нууц товчоон” дахь Жамухыг өгүүлэх нь” гэдэг эрдэм шинжилгээний бүтээлдээ Жамухын цэрэг дайны бодлогыг товойлгон сайшааж, чадамгай цэргийн бодлоготон гэж үзсэн. 1994 онд нийтэлсэн Д.Мөнхзаяагийн “Монголын нууц товчоо”-ны хүмүүсийн дүр (нэг)” гэдэг өгүүлэлд “МНТ”-ны Жамухын дүрийг зөвтгөсөн ба Жамух бол андын журмыг сахидаг, ухаан бодлоготой сэцэн хүн гэж түүний Тэмүүжингээс хагацсан шалтгааныг уйдамхай зангаас нь болсон гэдэг үзлийг буруушааж, энэ нь зөвхөн эрх ашгийн зөрчлийн үр дүн болохыг тодорхойлжээ. Б.Нарсу “Монголын нууц товчоо” дахь Жамухын дүрийн тухай өгүүлэх нь” гэдэг өгүүлэлдээ Жамухыг хүч чадал ухаан бодол хосолсон андын журмыг сахидаг гэдэг үзлийг дэвшүүлсэн ба “Монголын нууц товчоо” дахь Жамухын дүрийн судалгааны нарийвчлал

<sup>15</sup> Жөү Мэй Чиү. “Чингис хааны дүрийн уламжлалт болон хүлээн авалтын тухай өгүүлэх нь – “Монголын нууц товчоо”, “Юаний түүх”, “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар”-ын жишээн дээр. Бээжин. 2006.

<sup>16</sup> Жан Шү Пин. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Чингис хааны дүрийн харьцуулал судлал”. Бээжин. 2013.

<sup>17</sup> Ин Цүн. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-т илэрсэн Чингис хааны дүрийг харьцуулах нь”. Хөх хот. 2010.

<sup>18</sup> Үү.Тана. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-ын уран дүрийг харьцуулан шинжих нь”. 2003.

<sup>19</sup> Ч.Хишигтогтох. Монголын нууц товчооны судалгаа. 1981.

<sup>20</sup> То.Дэлгэрсан. Монголын нууц товчооны судлал. 1981.

<sup>21</sup> Мөн тэнд.



ба оришин байгаа асуудал” гэдэг өгүүллийг туурвиж “МНТ” - д тэмдэглэгдсэн Жамухын үйл ажиллагаа, үг ярианаас түүний зан чанарыг бүдүүвчлэн тоочиж болохгүй, бусад талаас нь харж зөвөөр үнэлэх хэрэгтэй гэж уриалсан байдаг. Ван Сэргэлэн “Монголын нууц товчоо” дахь Жамухын дүр” гэдэг өгүүлэлд Жамух үнэндээ үг хэлэндээ хурц, ухаан бодол гэгээн мэргэн, найр журмыг эрхэмлэдэг цэрэг дайны ухаантан бөгөөд нийгмийн ахиулагч гэж илэрхийлсэн байдаг. Ван Сү Мин “Ороо бусгаа ертөнцийн баатрын мөн чанар”, “Монголын нууц товчоон дахь “Жамухын дүрийн дахин шинжлэлт” гэх өгүүлэлдээ: “МНТ”-ны Жамухыг андын журмыг сахигч гэдэг үзлийг дэмжин, тэр нь баатар болохоос биш улс төрч биш гэж залруулав. Алтантогосын магистрын зэрэг хамгаалах “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Жамухын дүрийн харьцуулал”<sup>22</sup> гэдэг өгүүлэлдээ “МНТ” болон “Хөх судар”-т тэмдэглэсэн Жамухын удам угсааны дүрслэл, нөхөрлөлийн дүрслэл, зан чанарын дүрслэл зэргээс гардаж хоёр сурвалж бичиг дэх Жамухын дүрийн ялгаа зөрөөг шинжилсэн байна. Өгүүлэлд “МНТ” дах Жамух бол Чингис хааны Их Монгол улсыг нэгтгэх үйлсэд зохих гавьяа зүтгэл үзүүлсэн бөгөөд уужим ухаантай, хэлсэндээ хүрдэг, андын журмыг сахидаг зан чанарын онцлогийг илэрхийлжээ гэсэн байдаг. “Хөх судар” дахь Жамух зөвхөн Чингис хааны дайсан болох бөгөөд буруу талын дүрээр илэрхийлэгдсэн гэжээ.

Эдгээр үзэл санаануудын нийтлэг тал нь “МНТ” дах Жамухыг ухаан бодолтой, андын журмыг сахидаг гэж үзэхэд байдаг. Буян-Өлзий, Ван Сэргэлэн нар Жамухыг цэрэг дайны ухаантай гэж үзэж байсанд Ван Сү Мин түүнийг баатар хэмээн үнэлсэн байна.

Үүнээс гадна, Шо Жүн Фэн, Жан Рүн Ган нар “МНТ” дах Жамухын дүрийг сайн муу хоёр талаас нь илэрхийлж байв. Жан Рүн Ган “Монголын нууц товчоо “дахь хүмүүсийн дүрийн хэв шинжит чанар” гэдэг хятад өгүүлэлдээ үнэндээ Жамух Тэмүжинтэй мөр зэрэгцэн Монголын хаан болох хэр хэмжээтэй байсан ч түүний зан чанарын нөлөөнөөс болж ялагдсан гэсэн ба түүний найр журмыг эрхэмлэх үзлийг зөв гэж үзэв. Шо Жүн Фэнгийн “Жамухыг туршин өгүүлэх нь” гэх хятад өгүүлэлдээ Сэцэн мэргэн хирнээ тэнэг мунхаг, эрхэм дээд хирнээ эгэл дорд хэмээн үнэлсэн байна.

### **Хоёр. “Монголын Нууц Товчоо”-ны эмэгтэйчүүдийн дүрийн шинжлэл**

“МНТ”-ны эмэгтэйчүүдийн дүрийг судлах нь XIII зууны Монгол эмэгтэй хүний дүр төрх, нийгмийн байр суурийг тодруулахад чухал бөгөөд нэгэн үеийн хаан төрийг цогцлоход тухайн нийгмийн эмэгтэйчүүдийн хүч нөлөө ямар байр суурьтай байсныг ажиглаж болно.

БНХАУ дахь “Монголын нууц товчоо” судлалын хүрээнд “Монголын нууц товчоо”-ны эмэгтэй баатруудын дүр шинжлэлийг судалгааны агуулга, хэлбэрээр нь тусгай сэдэвт буюу дагнасан судалгаа, бүхэл цогц судалгаа гэж хоёр хэсэгт хувааж болно. Тусгай сэдэвт буюу дагнасан судалгаа нь “МНТ”-ны аль нэг эмэгтэй дүрээр судлагдахуун болгосныг өгүүлнэ. Норов, Сарангэрэл нарын судалгааны бүтээл нь “МНТ”-ны Бөртэ-Үжиний дүрийн судлалд дорвитой байр суурьтай. Норовын “Монголын нууц товчоо” дахь Бөртэ-Үжин хатны дүр” гэдэг өгүүлэлд Бөртэ-Үжинийг бэрхшээл зовлонгоос айн сүрдэхгүй зоригтой, тэсвэр хатуужилтай бөгөөд улс төрийн сонор сэрэмжээр сайтай сэцэн мэргэн ухаалаг бүсгүй хэмээжээ. Сарангэрэлийн “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Бөртэ-Үжиний дүрийн тухай товч өгүүлэх нь” (2013 он) өгүүлэлд хоёр сурвалжид илэрсэн Бөртэ -Үжинийг харьцуулан, “МНТ”-нд Бөртэ-Үжинийг их байр суурьтай бичсэн боловч “Хөх судар”-т харин Чингис хааны хүндэтгэлийг хүртээгүй, тэрчлэн маш доор байр суурьтайгаар бичигдсэн ялгааг тодруулав. Тэр бээр бас “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Өгэлүн эхийн дүрийн тухай товч өгүүлэх нь” гэдэг өгүүллийг нийтлүүлж хоёр сурвалж бичиг дэх Өгэлүн эхийн дүрийн талаарх шинжлэл хийсэн байна.

Тэгвэл бүхэл цогц судалгааны хүрээнд “МНТ”-нд гарч буй олон эмэгтэйчүүдийн дүрийг цогцоор нь судалж, үүгээр дамжуулан тэдгээр эмэгтэйчүүдийн нийтлэг онцлогийг нь

<sup>22</sup> Алтантогос. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Жамухын дүрийн харьцуулал. 2015.

эрэлхийлсэн судалгаа юм. Шү Ян, Фен Ти, Ү.Сарна, Вэн Хуан, Эрдэнэгоо, Ли Жиан Шин, Лян Мэй Лян нар “Нууц товчоо”-ны эмэгтэйчүүдийн дүр жич тэдний байр суурийн талаар судалж байжээ. Шү Ян, Фен Ти нарын “Эртний Монгол эмэгтэйчүүдийн байр суурийг товч шинжих нь” гэдэг өгүүлэлд “МНТ” дахь Өгэлүн эх, Бөртэ-Үжиний хамаарал бүхий тэмдэглэлийг үндэслэж эртний Монгол эмэгтэйчүүдийн байр суурь нь Хятад эмэгтэйчүүдээс илүү өндөр бат бэх байр суурьтай байсан, гэх дүгнэлтэд хүрсэн байна. Ү.Сарна “Монголын нууц товчоон дахь эмэгтэйчүүдийн дүрийн нотлол” гэдэг өгүүлэлдээ: Өгэлүн эхийг ачит эхээр үл барам агуу их улс төрийн том, холын зорилготой хүн болох тухай өгүүлсэн ба найрамдлыг эрхэмлэдэг зан чанарыг магтжээ. Бөртэ-Үжинийг “*Тэмүжиний ар түшиг ба оюун ухааных нь хамгаалагч нь болж байсан гавьяат бүсгүй юм*”<sup>23</sup> гэж үнэлэв. Үүнээс гадна Вэн Хуаны ““Монголын нууц товчоо” дахь эмэгтэйчүүдийн дүрийг шинжлэх нь”<sup>24</sup> гэдэг магистрын цол хамгаалах хятад өгүүлэл, Ли Жяа Шин-ий “Монголын нууц товчоо” дахь эмэгтэйчүүдийн байр суурийн шинжлэл” гэх өгүүлэл, Лян Мэй Ляны “Уугаал төрийн ухаалаг түшиг - Монголын нууц товчоо”- ноос эртний Монгол эмэгтэйчүүдийн байр суурийг шинжих нь “То. Дэлгэрсангийн ““Монголын нууц товчоо”-ны урлагийн онцлогийн тухай анхны ажиглалт” өгүүлэл нь, удаа дараагаар хэвлэгдсэн “Монгол үндэстний уран зохиолын түүх”-ийн “МНТ”-ны бүлгийн агуулгад МНТ-ны Өгэлүн эх, Бөртэ-үжин, Алунгоо/хатан/ эхийн дүрийн талаар задлан шинжилсэн байдаг.

БНХАУ-д “Монголын Нууц Товчоо”-ны эмэгтэй баатруудын дүрийн тухай янз бүрийн үзэл санаа дэвшүүлэгдэж, нэгдсэн ойлголт олон илрэв. Ингээд судалгааны тоймыг хураангуйлж үзвэл:

Нэгдүгээрт; Эртний Монгол эмэгтэйчүүдийн байр суурь маш өндөр бөгөөд Их Монгол улс байгуулагдахад зохих хэмжээний гавьяа зүтгэл үзүүлсэн гэх талаар Шү Ян, Фен Ти, Ү.Сарна, Вэн Хуан, Эрдэнэгоо, Ли жиан Шин, Лян Мэй Лян нар дурдсан байдаг.

Хоёрдугаарт; Өгэлүн эхийн тэсвэр хатуужилтай, улс төрийн хараа бодолтой агуу их эх хүний дүрийн тухай То.Дэлгэрсан, Сарангэрэл, Н.Сайшаалт, Ү. Сарна нар дурдсан байдаг.

Гуравдугаарт; Бөртэ-үжиний сэцэн сэргэлэн, Асвар цагаавар зан чанарын тухай Норов, Лян Мэй Лян, Ү.Сарна нар дурдсан байдаг.

Дөрөвдүгээрт; Алунгоо эхийн эв найрыг эрхэмлэх үзэл суртлын талаар Лян Мэй Лян, Ү. Сараана нар дурдсан байдаг.

#### Гурав. “Монголын Нууц Товчоо”-ны бусад дүрийн судлал, шинжлэл

БНХАУ-д “Монголын нууц товчоо”-ны Чингис хаан, Жамух, эмэгтэйчүүдийн дүрийг судалж байснаас гадна Хасар, Ван хан, Таян хан, Бодончар, Мухулай, Бэлгүтэй нарын бусад дүрийг бас судалж шинжилсэн байна. Гэвч энэ талаарх судалгаа цөөн байгаа бөгөөд ялангуяа Бодончар болон Хасарын дүрийг судалсан тусгай сэдэвт бүтээл мэр сэр байгаагаас бусад дүрийн тухай тусгай судалгаа өнөө хэр хараахан байхгүй байна. Харин холбогдол бүхий сэдэвтэй зарим нэг бүтээлд цухасхан дурдагдсан төдий л байна. Бодончарын тухай хамгийн анх судалсан хүн бол С. Өлзийбат юм. Тэрээр ““Боданчир мунхаг “Мунхаг бүс”” (1981) гэх богино илтгэл нийтлүүлж “МНТ” дахь Бодончартай хамаарал бүхий өгүүлэмжийг үндэслэн, Боданчир нь “мунхаг” биш “мэргэн” хэмээх анхны үзэл баримтлалаа дэвшүүлсэн байна. Дэлгэрийн үзэл санаа нь С.Өлзийбатын санаатай адил ба тэрээр ““Монголын нууц товчоо” дахь Бодончар болон түүний найруулга илэрхийлэл, соёл сэтгэл” гэх өгүүлэлдээ: Бодончарыг сөрөг талаас нь нотолсон эерэг талын дүр үзсэн байдаг. Энэ нь тус өгүүлэлд бас “МНТ”-ны зохиогчийн дүр бүтээх уран аргын үнэ цэнийн ач холбогдлын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн нь бий.

<sup>23</sup> Ү.Сарна “Монголын нууц товчоон дахь эмэгтэйчүүдийн дүрийн нотлол”

<sup>24</sup> Вэн Хуан. “Монголын нууц товчоо” дахь эмэгтэйчүүдийн дүрийг шинжлэх нь”. Бээжин. 2014

“МНТ” дахь Ван ханыг хувирамтгай, алсын бодлогогүй, чих зөөлөн зан чанарын тухай Д.Мөнхзаяа, Н.Сайшаалт, Ү.Тана нар санал нэгтэй байжээ. Таян ханыг санаа ихтэй оноо дорой, аймтгай дүрээр илэрхийлэгдсэнийг Д.Мөнхзаяа Н.Сайшаалт нар хүлээн зөвшөөрч өөрсдийн судалгаандаа дурдсан байна. Ниэ Шио Лин “Бодончарын улс төрийн үзлийг цухас өгүүлэх нь” гэх өгүүлэлдээ: “МНТ” болон бусад сурвалжид суурилан Бодончарын улс төрийн үзлийг түүний Боржигон овогтонг үүсгэн байгуулсан ба “бие тэргүүт дээл захт сайн” гэх ухагдахууныг дурдсанд илэрнэ гэсэн байв. Д.Мөнхзаяагийн “Монголын нууц товчоон дахь хүмүүсийн дүр” гэх өгүүлэлд Хасарыг “Хав хүч эрдэм чадлаараа цээж эрдэмт Тэмүжин ахдаа нэгэн сэтгэлээр тэмцэж”, дайны талбарт ид хүчээ гайхуулан яваа баатар эрийн дүрээр дүрслэгджээ гэсэн байна. Б.Мөнх “Монголын нууц товчоо”-нд дахь Хасар” гэх илтгэлдээ “бага насны Хасар, Хасарын үйл ажиллагаа, Хасарын үнэлэлт магтаал” зэрэг талаас Хасарын дүрийг задалсан боловч зан чанарын онцлогийн талаар үнэлээгүй байв. Лю Сүн Мэй “Нэгэн үеийн шидэт номч Хасарын дүр төрхийн онцлогийн тайлбар” (2016) гэх Хятад өгүүлэлдээ “МНТ” болон “Юаний түүх” зэрэг сурвалж бичгийг ашиглан Хасарын Их Монгол улсыг байгуулахад баларшгүй их гавьяа үзүүлсэн мөн ц түүнийг шидэт номчин, итгэлт түшмэл гэх мэтээр сайшаан магтсан байдаг.

Үүнээс гадна дээр дурдсан Д.Мөнхзаяагийн өгүүлэлд: “МНТ”-ны Алтан, Сэц бэхи зэрэг хүмүүсийн дүрийг анхлан шинжилж, Алтан, Сэц бэхи бол улс төрийн бодлогогүй, хуучин хэв ёсыг сахидаг алтан ургийн язгууртны төлөөлөгчийн дүрээр бичигджээ гэж үзэв. Өгүүлэлд бас Бэлгүтэйг гавьяардаггүй энэрэнгүй хирнээ эв найрамдлыг эрхэмлэдэг, уужуу сэтгэлтэй хүн мөн гэдгийг дурджээ. Ү.Тана “Монголын нууц товчоо” болон “Хөх судар “-ын уран дүрийг харьцуулан шинжлэх нь” гэдэг өгүүлэлд Мухулайг олон удаа гавьяа байгуулсан, ухаан самбаа хосолсон чин зоригт эгэлгүй баатрын дүрээр дүрсэлсэн хэмээн үнэлсэн байна. Жич: Монголын эзэнт гүрний үеийн суут жанжин, Гоо ван Мухулайн намтар, үйл хэргийн талаарх даацтай судалгаа өнөө хэр хараахан гараагүй байна. Энэ нь түүнтэй холбоотой сурвалжууд хятад улсын данс эвхмэлийн газарт үлдсэнээс бус бусад харь хэлнээ тэмдэглэгдэж үлдсэн зүйл судалгааны эргэлтэд ороогүй байна.

### Дүгнэлт

1949-2019 он хүртэл Хятад улсын “Монголын нууц товчоо” судлалын хүрээнд зөвхөн дүр шинжлэл нь эрчимтэй хийгдэж энэ талын судалгаан бүтээлүүд цөөнгүй нийтлэгдэж эрдэм шинжилгээний зохих түвшинд хүрч чадсан байна. Гэхдээ судалгааны сэдвийн давхцал, судалгааны үр дүнгийн ижилсэл, хэт нэг талыг барьж туйлширсан зэрэг асуудлууд оршсоор байна. Ялангуяа “Монголын нууц товчоо” зохиол дах эмэгтэйчүүдийн дүрийн судлал шинжлэл нэг зүйлийг давтсан, агуулга үзэл санаа нуруулан байдал тод илэрч байгаа зэрэг нь энэ чиглэлийн судалгааны ажлын дутуу дулимаг байгааг илэрхийлж байна.

Эзэн Чингис хаан, Жамух сэцэн, эмэгтэй баатруудын дүрээс бусад дүрийн судалгаа дангаар хийгдсэн нь тун цөөн байна. Мөн эдүгээг хүртэл Жамух сэцний дүрийн талаар янз бүрийн үзэл санаа дэвшүүлсэн хэдий ч нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байдалтай байна.

### Summary

“Secret History of Mongols” has been translated into many languages of the world and has reached the intellectual eyes of readers and researchers of many nations and has now reached tens of sixty editions. We are launching the Review of Secret History of Mongols Character Research to research, collect, and publish the entire work of Mongolian scholars abroad in the context of character research. The lifeblood of literature is “character” and the study begins with character analysis.

### Ном зүй

- Загчидсэцэн.** “Монголын нууц товчоо”-ноос Чингис хааныг харах. Өвөрмонголын “Өдрийн сонин” 1959.9.28. Хөх хот
- Хишигтогтох Ч.** 1981. “Чингис хаан-Монголын нууц товчоо”-ны хүмүүсийн зан чанарын тухай товч өгүүлэх нь. Хөх хот.
- Ван Мандуга.** 1990. Нууц товчооноос Чингис хааныг үнэлэх нь. Хөх хот.
- Сайшаалт Н.** 2017. Монголын уран зохиолын түүх. Хөх хот.
- Зо Бин Күн. Ли Гүй Жи.** 1980. Чингис хааныг туршин өгүүлэх нь. Хөх хот.
- Дамба Р.** 1993. Чингис хааны хүн хэрэглэх ухаан. Хөх хот.
- Ганболд Р.** 1993. Эзэн богд Чингис хааны дүр төрх. Хөх хот.
- Наран-Очир.** 2005. Чингис хаан бол агуу их бодолготон мөн. Хөх хот.
- Наран-Очир.** 2007. Чингис хааны итгэл бишрэлийн үзэл санаа-Чингис хаан бол агуу их бодолготон мөн гэх тухай гурвантаа өгүүлэх нь. Хөх хот.
- Дэлгэрсан Т.** 1981. “Монголын нууц товчоо”-ны урлагийн онцлогийн тухай анхны шинжлэлт. Хөх хот.
- Сайн.** 1990. “Монголын нууц товчоо” дахь олон давхаргат соёл. Хөх хот.
- Мөнхзаяа Д.** 1995. “Монголын нууц товчоо” -ны хүмүүсийн дүр”.
- Инжаннаши В.** 1957. Их Юань улсын мандсан төрийн Хөх судар.
- Жөү Мэй Чиү.** 2006. Чингис хааны дүрийн уламжлалт болон хүлээн авалтын тухай өгүүлэх нь - “Монголын нууц товчоо”, “Юаний түүх”, “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар”-ын жишээн дээр. Бээжин.
- Жан Шү Пин.** 2013. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Чингис хааны дүрийн харьцуулал судлал. Бээжин.
- Ин Цүн.** 2010. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-т илэрсэн Чингис хааны дүрийг харьцуулах нь. Хөх хот.
- Үү. Тана.** 2003. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар”-ын уран дүрийг харьцуулан шинжих нь.
- Хишигтогтох Ч.** 1981. Монголын нууц товчооны судалгаа.
- Дэлгэрсан То.** 1981. Монголын нууц товчооны судлал.
- Алтантогос.** 2015. “Монголын нууц товчоо” болон “Хөх судар” дахь Жамухын дүрийн харьцуулал.
- Сарна Ү.** 2010. “Монголын нууц товчоо”-дах эмэгтэйчүүдийн дүрийн нотлол. ӨМАХХороо. Хөх хот.
- Вэн Хуан.** 2014. “Монголын нууц товчоо” дах эмэгтэйчүүдийн дүрийг шинжлэх нь. Бээжин.
- 周美琼, 论成吉思汗形象的传播和接受 以 蒙古秘史 元史 和 青史演义 为例, 内蒙古师范大学学报, 2006年 第4期, 22 26页。